

ДУЛААН АЛДАГДЛЫГ БАГАСГАСАН БАРИЛГЫН 20 ... ОНЫ БҮРТГЭЛ

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

	код	
Дүүргийн нэр:		
Хорооны дугаар:		

1. Хорооны Засаг дарга нь жил бүрийн 12-р сарын 20-ны дотор бүртгэлийг цахим дүүргийн ЗДТГ-т хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хянаж, нэгтгэн нь 12-р сарын 25-ны дотор УБ хотын ЗАА цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

А	МД	Нийт	Үүнээс	
			Төвлөрсөн систем	Төвлөрсөн бус систем
Б	1	2	3	
Хорооны нутаг дэвсгэрт байгаа нийт барилга мөр 1= мөр (2+4)	1			
Дулааны алдагдалгүй барилга	2			
Шинээр барьсан барилга	3			
Дулааны алдагдалтай барилга	4			
Дулааны алдагдлыг багасгасан барилга мөр 5=мөр (6+7)	5			
Хана, адар, шал, дээврээ нэмж дулаалсан, стандартын цонх, хаалга шинээр суурилуулсан барилга	6			
Бусад аргаар дулааны алдагдалыг багасгасан барилга	7			

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Дулаан алдагдлыг багасгасан барилгын 20... оны бүртгэлийн маягт (ЭАБ-5) - ыг нөхөх заавар

Хорооны Засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаа дулааны алдагдлыг багасгасан барилгын бүртгэлийг сууц өмчлөгчдийн холбоо, орон сууц ашиглалт, нийтийн аж ахуйн үйлчилгээг хариуцсан байгууллагатай хамтран маягтын дагуу нэгтгэн гаргана.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил: Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- 01, Багахангай дүүрэг- 04, Баянгол дүүрэг- 07, Баянзүрх дүүрэг- 10, Налайх дүүрэг- 13, Сонгинохайрхан дүүрэг- 16, Сүхбаатар дүүрэг-19, Хан-Уул дүүрэг-22, Чингэлтэй дүүрэг- 25 гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө.

Хорооны дугаарыг “Хүн ам”-ын мэдээллийн санг байгуулах заавраас нөхнө. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон www.ubstat.mn цахим хуудсаас харах боломжтой.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

1 дүгээр мөрөнд: Хорооны нутаг дэвсгэрт байгаа нийт барилгын тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө. Дулааны төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй аж ахуйн нэгж, байгууллагын болон нийтийн, хувийн эзэмшлийн бүх төрлийн барилгыг хамруулан нийт дүнг нөхнө.

2 дугаар мөрөнд: Дулааны алдагдалгүй барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө. Дулааны алдагдалгүй барилгад хашилт хийц, цонх, хаалга, дээврийн дулаан дамжуулалтын итгэлцүүр нь дулаан техникийн сүүлийн үеийн нормативт нийцсэн буюу зураг төслийн дагуу баригдсан барилгыг хамруулна. Өөрөөр хэлбэл барилгын норм, нормативын шинэчлэлийн дагуу ханын дулаалгын үе нь 10 см-ээс доошгүй, дээвэр нь 15 см-ээс доошгүй зузаантай дулаалгын үе буюу хөөсөнцөр, эрдэс болон шилэн хөвөн, чулуун хөвөн дулаалгатай бүх барилгууд орно.

3 дугаар мөрөнд: Тайлан онд шинээр барьсан дулааны хэмнэлттэй барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө.

4 дүгээр мөрөнд: Дулаан алдагдалтай барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө.

5 дугаар мөрөнд: Дулааны алдагдлыг багасгасан барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө.

6 дугаар мөрөнд: Хана, адар (дээврийн хөндий), шал, дээврээ нэмж дулаалсан, стандартын цонх, хаалга шинээр суурилуулсан барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө. Хана, адар, шал, дээврээ нэмж дулаалсан, стандартын цонх, хаалга шинээр суурилуулсан барилгад эрчим хүчний хэмнэлт гаргах зорилгоор хуучин барилгаа дулаалж, цонх, хаалгаа шинэчилсний үр дүнд дулаан алдагдлаа 30-аас доошгүй хувиар багасгасан барилгыг оруулна.

7 дугаар мөрөнд: Дээр дурдсанаас бусад аргаар дулааны алдагдалыг багасгасан барилгын нийт тоог төвлөрсөн системд холбогдсон, холбогдоогүй эсэхээр нөхнө.